



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 1 сарын 26 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч
агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн
харъяа газруудын бүтэц, орон тооны тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлагуудын бүтэц, орон тооны хязгаарыг нэгдүгээр хавсралтаар, Улаанбаатар хотын Захирагчийн харъяа газруудын захиргааны бүтэц, орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан бүтэц, орон тоог чанд мөрдөж, байгууллагынхаа дүрэм, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг хэрэгжүүлэгч агентлагууд, харъяа газруудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

Гурав. Нийслэлийн төсвөөс санхүүжиж байгаа болон нийслэлийн өмчит ба өмчийн оролцоотой байгууллагуудын үйл ажиллагааг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлж, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Баатарзоригт даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2003 оны “Нийслэлийн Газрын албаны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 58 дугаар захирамжийн нэг, хоёрдугаар заалт, 2004 оны “Бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн тогтоох тухай” 370 дугаар захирамжийн тавдугаар заалт, 2003 оны “Мэргэжлийн хяналтын байгууллагын зохион байгуулалтын тухай” 39 дүгээр захирамжийн тавдугаар заалт, 2001 оны “Дүрэм, бүтэц орон тоог батлах тухай” 12 дугаар захирамжийн хоёрдугаар заалт, 2004 оны “Иргэний бүртгэл мэдээллийн албаны дүрэм, орон тоог шинэчлэн батлах тухай” 14 дүгээр захирамжийн хоёрдугаар заалт, 2001 оны “Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, дүрэм, орон тоог батлах тухай” 16 дугаар захирамжийн дөрөвдүгээр заалт, 2001

Б.Н.Н.

02000671

оны "Дүрэм, орон тоог батлах тухай" 11 дүгээр захирамжийн хоёрдугаар заалт, 2004 оны "Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны тухай" 08 дугаар захирамж, 2001 оны "Дүрэм, орон тоог батлах тухай" 09 дүгээр захирамжийн хоёрдугаар заалт, 2000 оны "Бүтцийн өөрчлөлт хийх, дүрэм, орон тоо батлах тухай" 18 дугаар захирамжийн тавдугаар заалт, 2001 оны "Дүрэм, орон тоог батлах тухай" 10 дугаар захирамжийн хоёрдугаар заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2005 оны
1 дүгээр сарын 26... ны өдрийн
22. дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГУУДЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Хэрэгжүүлэгч агентлагуудын нэр	Нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Эрүүл мэндийн газар	Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс Мэдээлэл, эмнэлгийн тусламжийн хэлтэс	20 хүртэл үүнээс удирдлага 2
2	Биеийн тамир, спортын хороо	-	6 хүртэл үүнээс удирдлага 1
3	Хүүхэд, залуучуудын газар	Хүүхэд, залуучуудын хэлтэс Захиргаа, аж ахуйн тасаг	11 хүртэл үүнээс удирдлага 2
4	Байгаль хамгаалах газар	-	42 хүртэл үүнээс удирдлага 2
5	Боловсрол, шинжлэх ухааны газар	Захиргааны удирдлагын хэлтэс Мэргэжил арга зүйн алба	26 хүртэл үүнээс удирдлага 2
6	Соёл, урлагийн газар	-	7 хүртэл үүнээс удирдлага 1
7	Иргэний бүртгэл мэдээллийн алба	Захиргаа, аж ахуйн тасаг Гэр бүлийн байдлын бүртгэлийн хэлтэс Архивын тасаг Үнэмлэх бүртгэл хяналтын хэлтэс	40 хүртэл үүнээс удирдлага 2
8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар /Харьяандаа Хөдөлмөрийн биржтэй/	-	7 хүртэл үүнээс удирдлага 1
9	Нийтлэг үйлчилгээний газар	-	122 хүртэл үүнээс удирдлага 2
10	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Хүнсний хэлтэс Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс Газар тариалангийн хэлтэс	15 хүртэл үүнээс удирдлага 2
11	Мал эмнэлгийн газар	Мал эмнэлгийн хэлтэс Захиргаа, аж ахуйн тасаг Лаборатори	23 хүртэл үүнээс удирдлага 2
12	Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн	Бүс нутгийн сектор Хот төлөвлөлтийн хэлтэс Мэдээллийн төв	50 хүртэл үүнээс удирдлага 2

13	Авто замын газар	Захиргаа, аж ахуйн тасаг Барилга угсралт, засварын хэлтэс Төлөвлөлт, судалгааны хэлтэс Ашиглалтын хэлтэс	20 хүртэл үүнээс удирдлага 2
14	Хөрөнгө оруулалтын газар	Захиргаа, аж ахуйн тасаг Барилга, инженерийн шугам сүлжээний хэлтэс Төслийн хэлтэс	27 хүртэл үүнээс удирдлага 2
15	Өмчийн харилцааны газар	Захиргаа, аж ахуйн хэлтэс Төлөөллийн хэлтэс Бүртгэл хяналтын хэлтэс Өмч хувьчлалын хэлтэс	35 хүртэл үүнээс удирдлага 2
16	Мэдээлэл, технологийн газар	Мэдээллийн сангийн алба Техник, технологийн алба	15 хүртэл үүнээс удирдлага 2
17	Архивын газар	-	10 хүртэл үүнээс удирдлага 1
18	Цагдаагийн газар	Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс Захиргааны удирдлагын хэлтэс Хэв журмын хэлтэс Олон нийтийн харилцааны хэлтэс Жижүүрийн шуурхай албаны удирдлагын төв Холбооны тасаг	231 хүртэл үүнээс удирдлага 2
19	Статистикийн газар	-	8 хүртэл үүнээс удирдлага 1
20	Нийгмийн даатгалын газар	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс Эрүүл мэндийн даатгалын хэлтэс Бүртгэл санхүү, тооцооллын хэлтэс	31 хүртэл үүнээс удирдлага 2
21	Газрын алба	Тамгын хэлтэс Газар зохион байгуулалтын хэлтэс Газрын кадастрын хэлтэс Газар өмчлөлийн хэлтэс Газрын төлбөрийн хэлтэс Мэдээллийн төв	120 хүртэл /Дүүргүүдийн Газрын албаны хамт/ үүнээс удирдлага 2
22	Гамшгаас хамгаалах штаб	Мэргэжлийн удирдлагын хэлтэс Тамгын хэлтэс Хяналт шалгалтын хэлтэс Нөөцийн алба	85 хүртэл үүнээс удирдлага 2
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба	-	90 хүртэл үүнээс удирдлага 2



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
1 дүгээр сарын 26-ны өдрийн
22 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ХАРЪЯА ГАЗРУУДЫН ЗАХИРГААНЫ
БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Харъяа газруудын нэр	Нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Ус сувгийн удирдах газар	Захиргаа, боловсон хүчний хэлтэс Төсөв санхүү, эдийн засгийн хэлтэс Үйлдвэр техникийн хэлтэс Хангамж үйлчилгээний хэлтэс	36 хүртэл үүнээс удирдлага 2
2	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар	Захиргаа, боловсон хүчний хэлтэс Санхүүгийн хэлтэс Инженерийн бодлогын хэлтэс	30 хүртэл үүнээс удирдлага 2
3	Нийтийн тээвэр зохицуулалтын газар	Захиргаа, боловсон хүчний хэлтэс Тээврийн хэлтэс Хөдөлгөөн бүртгэл мэдээллийн хэлтэс Эдийн засаг, санхүүгийн хэлтэс Хяналт шалгалтын хэлтэс	70 хүртэл үүнээс удирдлага 2
4	Халаалтын зуухны ашиглалт, зохицуулалтын газар	-	25 хүртэл үүнээс удирдлага 2
5	"Гэрэлтүүлэг чимэглэл" компани	-	11 хүртэл үүнээс удирдлага 2
6	"Цэцэрлэгжилт" компани	-	11 хүртэл үүнээс удирдлага 1
7	"Улаанбаатар-зам засвар, арчлалт" компани	-	16 хүртэл үүнээс удирдлага 2
8	"Усны барилга байгууламж" компани	-	7 хүртэл үүнээс удирдлага 1
9	"Нөөц" компани	-	6 хүртэл үүнээс удирдлага 1